

ГЭРТЭЭ ЦАХИМ ОРЧНЫ АЮУЛГВИ БАЙДЛЫГ САХИХ НЬ



Lantuun Dohio

UNITED AGAINST CHILD ABUSE & HUMAN TRAFFICKING

Өнөө үед томчууд, хүүхдүүд бүгд л ажил сургуулийн болон бусад шугамаар цахим орчныг хэрэглэдэг болсон тул цахим орчин дахь аюулгүй байдал хэзээ хэзээнээс илүү чухалд тооцогдох боллоо.

Хүүхдүүдийнхээ цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах, гэрээсээ цахим орчинд аюулгүй холбогдохын тулд дараах **таван зөвлөмжийг** дагаарай.

Зөвлөмж 1:

Гэрийн Дүрмүүдээ
Тогтоогоорой!



Цахим орчинд хийдэг бидний үйлдлүүд маш их өөрчлөгдсөн ч бид өөрсдийн гэр бүл болон цагийн хуваарьт тохирох дүрмүүдийг хүүхдүүдтэйгээ хамт гаргаж, хамтдаа дагаж мөрдөх боломжтой.

Үүнд:

- Цахим орчинд орох эсвэл видео тоглоом тоглохоосоо **өмнө** даалгавраа хийсэн байх
- Хооллох үедээ **гар утас, таблет, нөтбүүкээ ашиглахгүй** байх
- Өдөр бүр доод тал нь **минут** электроник төхөөрөмж оролцохгүй зүйл хийх
- “**Цахим Хорионы Цаг**”: Тогтсон цагаас хойш гар утас, таблет, нөтбүүкээ ашиглахгүй байх

Зөвлөмж 2:

Хяналтаа
Тохируулаарай!




Хамгийн сайн хяналтын програмтай, блоклох тохиргоотой байлаа ч цахим орчинд хүүхдүүдийг 100% хамгаалж чадахгүй. Харин тэдэнд анхаарал тавьж, цахим орчинд хэрхэн биеэ авч явах талаар идэвхтэй ярилцаж байх нь хамгийн сайн хамгаалалт болдог.

Үүнд:

Хүүхдүүддээ зориулж цахимаар суралцах **булан** бүрдүүлж өгөөрэй. Ингэхдээ дэлгэцийг нь эцэг эх ба асран хамгаалагчид гэрийнхээ ажлыг хийх зуураа эсвэл гэрээсээ цахимаар ажиллаж байх үедээ **амархан шалгаж болох, нүдэнд өртөхүйц** газар байрлуулаарай.

Зөвлөмж 3:

Цахим
Платформуудыг
Судлаарай!




Гэрээсээ цахимаар ажиллаж байгаа үедээ хүүхдүүдийнхээ ашиглах дуртай цахим платформуудыг сайтар судалж үзээрэй. Хүүхдүүдийнхээ тоглож буй тоглоом болон ашиглаж буй платформуудыг хамтдаа сонирхож, тэдэнтэй ярилцсанаар цахим орчинд тэдний юу хийж байгааг ойлгоход туслах болно.

Үүнд:

Хэрвээ гэрээсээ цахимаар ажиллаж байгаа бол ажлынхаа дундуур **багахан завсарлага авч** хүүхэдтэйгээ **хамт видео тоглоом тоглох** эсвэл тэдний ашигладаг цахим платформуудын нэг дээр харсан **хөгжилтэй зураг эсвэл видеог** тэдэн рүү илгээж болно. Ингэснээр хүүхдүүдийнхээ цахим орчин дахь амьдралд оролцох хүсэлтэйгээ илэрхийлж байна гэсэн үг юм. .

Зөвлөмж 4:

Хамтдаа Суугаад
Ярилцаарай!



Хамтдаа суугаад хүүхдүүдтэйгээ ярилцаж байгаарай. Бидний амьдрал тэр чигтээ цахим орчин дахь харилцаан дунд өрнөж байгаа тул хүүхдүүд тань цахим орчинд бусадтай ямар харилцаа үүсгэж байгаа талаар тэдэнтэй нүүр нүүрээ харан нээлттэй ярилцах нь чухал. Ингэж ярилцах үедээ цахим орчинд тохиолдож буй өөр бусад таагүй асуудлын талаар ярилцах боломжийг тэдэнд өгч байгаарай.

Үүнд:

Анхааралтайгаар сонсож, ямар ч асуудал байсан **тайвнаар хүлээж авч**, тэдэнтэй ярилцана гэдгээ харуулаарай.

Зөвлөмж 5:

Цахим
Төхөөрөмжүүдийг нь
Бүү Хураан Аваарай!



Хүүхэд тань цахим орчинд буруу зүйл хийсэн байлаа ч тэднийг цахимд орохыг нь шууд хязгаарласнаар үүссэн асуудлыг шийдвэрлэх нь ховор. Ялангуяа хөл хорионы үед ийм шийдвэр гаргах нь сайнаар биш муугаар нөлөөлөх нь бий. Хүүхдүүд цахимаар сурч боловсрох боломжгүй болохоос гадна найз нөхөд болон хамаатнуудаасаа тусгаарлагдаж, нийгмийн харилцаа нь алдагдах юм. Тэгэхээр аль болох цахим орчинд орох эрхийг нь бүрэн хязгаарлалгүйгээр хийсэн үйлдлийнх нь үр дүнг ухааруулах арга замыг эрэлхийлээрэй.

Үүнд:

Хэрвээ шаардлагатай бол цахимд орох хугацааг нь хязгаарлаж болно. Цахим платформууд ашиглах, видео тоглоом тоглох зэрэг **хугацааг нь богиносгох**, болон гэрийнхээ тодорхой хэсгүүдэд цахим төхөөрөмжүүд ашиглахгүй байх зэргээр хязгаарлалт тогтоож болно.

NetSmartz®

© This document was translated by Lantuun Dohio USA from an original document created by the National Center for Missing and Exploited Children (NCMEC). Original documents can be found at ncmec.org/netsmartz/resources. Any grammatical, technical issues, or deviations from the source material are the sole responsibility of Lantuun Dohio USA.

A program of the

